



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 27 өдөр

Дугаар АБ15

Булган сум

“Булган органик” зөвлөх үйлчилгээг
хэрэгжүүлэхэд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, “Шинэ хөдөө сэргэлт” хөтөлбөрийн 4.4.8 дахь заалт, аймгийн Засаг даргын 2026 оны 97 дугаар “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг батлах тухай” захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн төмс, хүнсний ногооны хангамжийг нэмэгдүүлэх, органик бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, чанарыг баталгаажуулах зорилгоор “Булган органик” зөвлөх үйлчилгээг “Ногоон зам ногоочдын нэгдсэн холбоо” НҮТББ-аар гүйцэтгүүлсүгэй.

2.Булган органик зөвлөх үйлчилгээнд шаардагдах 20,000,000 (хорин сая) төгрөгийг “Шинэ хөдөө” сэргэлт хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

3.Маркетингийн зөвлөх үйлчилгээг гэрээний дагуу чанартай хийлгэж, хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Н.Пүрэвсайхан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

